



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f facebook.com/Rtcc.m0n
globe http://rtcc.mrtd.gov.mn
envelope info@rtcc.mrtd.gov.mn
phone +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2024 оны 03 дугаар сарын дугаар



Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд:

Радио давтамж тодорхойлогч (RFID - Radio Frequency Identification) технологи нь RFID уншигч, антенн, RFID шошгоос бүрддэг. Тус технологи нь ажиллах зарчмаасаа хамааран 2 төрөл байдаг. Төмөр замын салбарт “Идэвхгүй” буюу Passive төрлийн төхөөрөмжийг ашиглана. Антен нь уншигчаас радио долгионы тодорхой давтамжийг шошго руу дамжуулдаг. Passive RFID шошгыг идэвхжүүлж доторх мэдээллийг зөөгч долгионы тусламжтай уншигчруу буцаан илгээж, мэдээллийг хүлээн авах зарчимаар ажилладаг.

rtcc.mrtd.gov.mn

RFID шошго

TRANS CORE

Радио Давтамжаар Тодорхойлох ...

R F I D

Radio frequency identification

"Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэх замаар Монгол Улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг сайжруулах төсөл"



"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн санд хоногийн 450 мэдээ, сарын 36 мэдээг бүрдүүлж мэдээллийн нэгдсэн санд байршиж байна. ЗТХ-ийн сайдын 2020 оны А/154 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам", ЗТХ-ийн 2021 оны "Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл авах, мэдээллийн сан бий болгох заавар, маягт, нөхөх заавар, үзүүлэлт батлах тухай" А/93 дугаар тушаалын хүрээнд ЗТХЯ, Үндэсний статистикийн хороонд сар, улирлын статистик мэдээг албан бичиг болон цахим шуудангаар хүргэж тайлагнасан. Суурь бүтэц эзэмшигчийн тээвэрлэсэн ачааны хэмжээ (импорт, экспорт, дамжин өнгөрсөн, орон нутаг-тонн), чингэлэг тээвэрлэлт (импорт, экспорт, орон нутаг, транзит-тонн), зорчигч тээвэрлэлт (олон улс, орон нутаг-хүн) 2024 оны 02 дугаар сарын ачаа тээврийн статистик мэдээг нэгтгэн болосруулж 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдөр төвийн цахим хуудас, олон нийтийн сүлжээнд байршуулж мэдээлсэн.



ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Галт тэрэгний хөдөлгөөн
зохицуулалтын нэгдсэн төв

АЧАА, ТЭЭВРИЙН СТАТИСТИК МЭДЭЭ

1

СУУРЬ БҮТЭЦ ЭЗЭМШИГЧЭЭР ТЭЭВЭРЛЭСЭН АЧААНЫ МЭДЭЭ /ТОННООР/



5 639 200 тн ❖ Импорт: 680 600 тн ❖ Дамжин өнгөрсөн: 854 700 тн
Үүнээс: ❖ Экспорт: 1 750 100 тн ❖ Орон нутаг: 2 353 800 тн



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ

Төмөртэй өртөө: 26 842 тн
Үүнээс:
❖ Төмрийн хүдэр: 26 842 тн
Цогцэций өртөө: 120 287 тн
Үүнээс:
❖ Орон нутаг: 8951 тн
❖ Экспорт: 43141 тн
❖ Импорт: 16585 тн
❖ Мидлинг: 51 610 тн



374 500 тн

Үүнээс:
❖ Нүүрс: 340 980 тн



❖ Төмрийн хүдэр: 618 310 тн



❖ Нүүрс: 45 930 тн

2

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ [хүн]

Зорчигч тээвэрлэлт: 293 400 хүн
Үүнээс:
❖ Олон улс: 3 700 хүн
❖ Орон нутаг: 289 700 хүн

3

ЧИНГЭЛЭГ ТЭЭВЭРЛЭЛТ

Чингэлэг тээвэрлэлт: 1 249 874 тн
Үүнээс:
❖ Импорт: 127 248 тн
❖ Экспорт: 441 662 тн
❖ Орон нутаг: 30 520 тн
❖ Транзит: 680 443 тн




Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдээг танилцуулах



ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Галт тэрэгний хөдөлгөөн
зохицуулалтын нэгдсэн төв

НЭГДСЭН ЗУРМАГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ /ЭХНИЙ 15 ХОНОГООР/




2024 оны 02 дугаар сарын тасалдалд дүн шинжилгээ хийж, СХГ-д 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 150 дугаарын албан бичгээр танилцуулсан. 2024 оны 02 дугаар сарын нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, суурь бүтцүүдэд 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр ЗДТБЗГ-д албан бичгээр хүргүүлсэн. Нэгдсэн зурмагийн дүнгийн хурлыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, МТЗ, УБТЗ, ТТЗ, МТЛ суурь бүтцүүдийн төлөөлөл оролцож, 2023 оны болон 2024 оны эхний 2 сарын байдлаар нэгдсэн зурмагийн

дүн шинжилгээг танилцуулж, 2024 оны зуны зурмагийн саналд мидлинг тээврийг хэрхэн тусгах талаар санал солилцож, шийдвэр гаргаж ажилласан. Хилийн болон суурь бүтэц хоорондын солилцооны хоногийн нэгтгэлийг гарган, 2024 оны 03 дугаар сарын 1,16 өдрүүдэд инфографик мэдээгээр танилцуулсан. Нэгдсэн технологийн түр горимыг хэрэгжүүлэн, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн суурь бүтцүүдийн хоорондын солилцооны мэдээг нэгтгэн, тээвэрлэсэн ачааны мэдээг өдөр бүр, мидлинг тээврийн мэдээг 7 хоног бүр танилцуулан, хяналт тавьж ажилласан.



ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
Галт тэрэгний хөдөлгөөн
зохицуулалтын нэгдсэн төв

НЭГДСЭН ЗУРМАГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ (сүүлийн 16 хоногор)



2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 151 тоот албан бичгээр "ТТЗ" ХХК-д 152 тоот албан бичгээр "МТЗ" ТӨХК-д олон улсын төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцох төмөр замын байгууллагын RICS кодыг авах талаар зөвлөмж хүргүүлсэн.



Галт тэрэгний техникийн хурд, хэсгийн хурдын судалгаатай танилцаж, чичиргээний аргаар цахилгаан үүсгэх бичил төхөөрөмжийг 45-50км/цагийн хурдтай галт тэрэг аялах явцад хамгийн их энерги хуримтлуулах боломжтой болохыг тодорхойлж, тус хурдад нийцүүлэн энерги хуримтлуулагчийг бүтээхээр төлөвлөн ажиллаж байна. “Ачааны галт тэрэгт хоорондын замд аялах явцад үүсэх чичиргээний зонхилох давтамжийг тодорхойлж тус давтамжид үндэслэн хөдөлгөөний системүүдийг тэжээх боломжийн судалгаа, туршилт”-ыг “ТТЗ” ХХК-ны I-р зэрэглэлийн төмөр замд турших хүсэлтийг 2024.03.28-ны өдөр 238 тоот албан бичгээр хүргүүлж, туршилт, судалгаа хийхэд хамтарсан ажлын хэсэг байгуулах хүсэлт гаргаад байна



“УБТЗ” ХНН-ийн Дохиолол холбооны 2-р ангиас БГД-ийн 20-р хороонд шинээр баригдах “ГТХЗНТ”-ийн барилга хүртэл ТНГ-006-2024 (1-р чиглэл), D-U2023/142 (2-р чиглэл) техникийн нөхцөлийн дагуу гадна холбоожуулалт, худаг сувагчлалын зураг төслийн ажлыг боловсруулах “ажлын даалгавар”-ын төслийг боловсруулан “Төв”-ийн холбогдох албан хаагчдаас санал авч, 2024.03.28-ны өдөр 237 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБЗГТЗХ-д танилцуулахаар хүргүүлээд байна. УБТЗ ХНН-ийн Дохиолол

холбооны II р ангид 2024.02.20-ны өдрийн 114 тоот албан бичиг хүргүүлж, шинээр баригдах барилгын гадна холбоожуулалт, худаг сувагчлалын техникийн нөхцөлийг 2024.03.11-ны өдөр ТНГ-006-2024 дугаартай шинэчлэн гаргуулан батлуулсан.

Төмөр замын тээврийн салбарт хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах RFID (Radio frequency identification - Радио давтамжаар тодорхойлох) хяналтын систем нэвтрүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага /ажлын даалгавар/-ын төслийг боловсруулан ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-д 2024.03.28-ны өдөр санал авах, чиглэл хүсэх тухай 242 тоот албан бичгийг хүргүүлээд байна.



“Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:



"Смарт деливери монголиа" ХХК-д 2024.03.04-ний 147 дугаартай албан бичгээр түрээсийн 100 хагас вагоныг урьдчилан олгосон дугаар хүчингүй болгосон. "Монголиантранс ложистик" ХХК-д 2024.03.12-ний 153 дугаартай албан бичгээр түрээсийн 200 хагас вагонд, "Монцемент билдинг материалс" ХХК-д 2024.03.28-ний дугаартай албан бичгээр түрээсийн 40 хагас вагонд тус тус урьдчилан дугаар олгосон. "Дулаанвинг" ХХК-д 154 дугаартай албан бичгээр 2024.03.11-ний 56/24 дугаартай албан бичгэнд хариу албан бичиг хүргүүлсэн. "Тавантолгой төмөр зам" ХХК-д 2024.03.18-ний 172 дугаартай албан бичгээр түрээсийн 2 зүтгүүрыг мэдээллийн санд бүртгэсэн. "УБТЗ" ХНН-д 2023.03.20-ний 175 дугаартай албан бичгээр вагон тооллогийн тухай албан бичиг явуулж, 177- дугаартай албан бичгээр 51 компанид тус тус албан бичиг хүргүүлсэн. "Бэст даймонд" ХХК-д 2024.03.28-ний 239 дугаартай албан бичгээр түрээсийн 1 вагоныг мэдээллийн сангаас хасалт хийж, 1 вагоныг мэдээллийн санд бүртгэсэн.





**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

